



**ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2025 оны 06 сарын 26 өдөр

Дугаар А/550

Баян-Өндөр сум

┌ Хяналт шалгалт хийх ажлын хэсэг
байгуулах тухай ┐

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хүнсний тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, 10.2 дахь хэсэг, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1, 18.1.2, 18.1.3, 18.1.4 дэх заалт, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 8.1.3 дахь заалт, “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх Орхон аймгийн 2022-2027 оны төлөвлөгөөний 1.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хүнсний томоохон захуудад хяналт шалгалт хийх, иргэд, хэрэглэгчдээс ирүүлсэн өргөдөл гомдлыг шийдвэрлэх, санал танилцуулах Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:

С.Даваадорж (Аймгийн ЗДТГ-ын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга)

Ш.Сүнжидмаа (Аймгийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтсийн Авто замын хяналтын улсын байцаагч)

М.Анхбаяр (Аймгийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтсийн Эрчим хүчний хяналтын улсын байцаагч)

Гишүүд:

Н.Эрдэнэзул (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Газар, геодези, зураг зүйн хяналтын улсын байцаагч)

Б.Буянцогт (Хүнс, хөдөө аж ахуйн газрын Хяналтын хэлтсийн дарга, улсын байцаагч)

П.Алтанжаргал (Хүнс, хөдөө аж ахуйн газрын Таримал ургамлын үр сортын хяналтын улсын ахлах байцаагч)

Э.Даринчулуун (Хүнс, хөдөө аж ахуйн газрын Хүнсний чанар, стандартын хяналтын улсын байцаагч)

Д.Лхагважав (Эрүүл мэндийн газрын Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч)

С.Эрдэнэтунгалаг (Эрүүл мэндийн газрын Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч)

Д.Эрдэнэбаяр (Хөдөлмөр, халамж, үйлчилгээний газрын Хөдөлмөрийн хяналтын улсын ахлах байцаагч)

Ж.Баяржаргал (Хөдөлмөр, халамж, үйлчилгээний газрын Хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч)

П.Эрдэнэжаргал (Мал эмнэлгийн газрын Мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч)

Н.Азхүү (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилгын техникийн хяналтын улсын байцаагч)

Д.Мягмар (Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгийн дарга)

Нарийн бичгийн дарга:

Б.Баасансүрэн (Аймгийн ЗДТГ-ын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн)

2.Улсын байцаагчид чиг үүргийн дагуу хяналт, шалгалтын ажлыг үр дүнтэй, шуурхай зохион байгуулах, гарсан санал, дүгнэлтийг танилцуулахыг Ажлын хэсгийн дарга (С.Даваадорж)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ЗОРИГТБАЯР